



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/255

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“МУБИС-ийн дүрэм”-ийн 4.4.1, 4.4.10 дахь заалтууд, Захирлын зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУБИС-ийн “Лавай” сэтгүүлийг онлайн нээлттэй сэтгүүл болгох ажлын хүрээнд тус сэтгүүлийн эрхэлж буй шинжлэх ухааны чиглэлийг англи хэлээр “Lawai Journal of Education” хэмээн томъёолсугай.


2. МУБИС-ийн “Лавай” болон бүрэлдэхүүний сургуулиас эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, МУБИС-ийн “Лавай болон бүрэлдэхүүний сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүлийг үнэлэх аргачлалыг 2 дугаар хавсралт, МУБИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл бичих шаардлагыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “МУБИС-ийн “Лавай” болон бүрэлдэхүүний сургуулиас эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах журам”-ыг эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцын үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг сэтгүүлийн ерөнхий редактор, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал (Д.Наранцэцэг)-д даалгасугай.

5. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан МУБИС-ийн захирлын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/53 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



О.АЛТАНГОО

2021.12.14

**МУБИС-ийн “Лавай” болон бүрэлдэхүүний сургуулиас эрдэм
шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Журам нь “МУБИС-ийн Хөгжлийн бодлого 2014-2024”, “Оюуны өмчийн талаар баримтлах бодлого” түүнд хамаарах бусад дүрэм журам, олон улсын стандарт шаардлагад нийцсэн байна.
- 1.2 Энэхүү журам нь Монгол улсын боловсролын их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновацын алба (цаашид “ЭШИА” гэнэ) болон бүрэлдэхүүний сургууль, төвөөс мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүл (цаашид “сэтгүүл” гэнэ) эрхлэн гаргах үйл ажиллагааны зарчим, субъект хоорондын эрх үүрэг, тэдгээртэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.3 Сэтгүүл нь нийтлэлийн бодлого, өгүүллийн агуулга ба бүтэц, нийтлэг шаардлага, сэтгүүлийн редакц, цаглавар, санхүүжилт, удирдлага зохион байгуулалт гэсэн бүтэцтэй байна.
- 1.4 Сэтгүүл нь олон улсын стандартад нийцсэн хэвлэмэл (ISSN¹) болон цахим (eISSN) цуврал дугаартай байна.
- 1.5 Сэтгүүл нь эрхлэн гаргасан гишүүдийн овог нэр, сургуулийн албан хаяг, утас, цахим шуудангийн хаяг зэргийг багтаасан байна.
- 1.6 Сэтгүүлийг эрхлэн гаргах албан ёсны хэл нь Монгол байх ба хураангуйг Англи хэлээр бичнэ.

Хоёр. Нийтлэлийн бодлого

- 2.1 Сэтгүүлийн нийтлэлийн бодлого нь МУБИС-ийн профессор багш, эрдэмтэн судлаач, суралцагчдын шинжлэх ухааны мэдлэг, чадвар /арга/, сэтгэлгээг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх, шинэ мэдлэг, технологи, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, нийгэмд сурталчлах, улмаар түүнийг нийтийн баялаг болгон ашиглахад чиглэгдэнэ.
- 2.2 Сэтгүүлд хэвлэгдэх бүтээлийн агуулга нь шинжлэх ухааны тухайн салбарын тулгамдсан асуудлын хүрээнд тодорхой асуудлыг орчин үеийн онол, арга зүйн түвшинд судалж, шинэ нээлт, ажиглалт, дүгнэлт хийж, асуудал дэвшүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон МУБИС-ийн судалгааны тэргүүлэх болон хавсарга судалгааны чиглэлээр бичигдсэн байна.
- 2.3 “Лавай” болон бүрэлдэхүүний сургуулийн сэтгүүл нь зорилго чиглэлээ тодорхойлсон ойрын болон алсын хараа, эрхэм зорилготой байна. Ойрын зорилго нь (JOL)² цахим хувилбартай болох ба 5 жилийн дотор олон улсын бүртгэлийн “Clarivate analytics”-н Web of Science, “Scopus” эсвэл “Scholar google” өгөгдлийн санд бүртгүүлж, индекслэгдсэн байна. Сэтгүүлийн талаарх мэдээлэл, МУБИС-ийн вэбсайт: laval.msue.edu.mn дотор байршуулна. Бүрэлдэхүүний сургуулийн сэтгүүлийн талаарх мэдээлэлmsue.edu.mn дотор байршина.
- 2.4 Сэтгүүл нь нийтлэлийн туршлага, олон улсын JPPS³ стандартын зэрэглэлээрээ онлайн хэлбэртэй болж болно.

¹ “Лавай” сэтгүүл (ISSN 2410-4507)

² JOL- Journal online

³ JPPS – Journal publishing practice and standards. <https://www.journalquality.info/en/>

- 2.5 МУБИС-ийн "Лавай" болон бүрэлдэхүүний сургуулийн сэтгүүлүүд шинжлэх ухааны чиглэлийг давхардуулахгүйгээр сэтгүүлийг эрхэлж, хөгжүүлэлтийг зохион байгуулна.
- 2.6 МУБИС болон бүрэлдэхүүний сургуулиас санхүүжилт авч буй эрдэм шинжилгээний сэтгүүл бүр хянан магадалгаа бүхий сэтгүүл байна. Өөрөөр хэлбэл сэтгүүл бүр өгүүллийг өдөр бүр хүлээн авна. Өгүүлэлд заавал хөндлөнгийн хянан магадалгаа хийнэ. /Predatory сэтгүүлийн технологиор үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 2.7 Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл олон улсын бүтээлийн сангийн (Ouriginal, Plagscan гэх мэт) байрших ба зохиогчийн эрх бусад хууль тогтоомжийн дагуу хамгаалагдана.
- 2.8 Сэтгүүлд хэвлэгдсэн бүтээлийг олон улсын бүтээлийн санд байршуулна.
- 2.9 Лавай болон бусад сэтгүүлүүд хэвлэгдэх өгүүллийн өгөгдлийг албан ёсны лицензтэй программаар боловсруулахыг шаардана.

Гурав. Сэтгүүлийн редакц /Editorial Board/

- 3.1 МУБИС-иас эрхлэн гаргаж буй Лавай сэтгүүлийн редакцыг МУБИС-ийн Захирлын тушаалаар, төв бүрэлдэхүүн сургуулиас эрхлэн гаргаж буй сэтгүүлийн редакцыг харьяалах бүрэлдэхүүний сургуулийн захирлын тушаалаар байгуулна.
- 3.2 Редакц нь эрхлэгч, нарийн бичгийн дарга, туслах редактор, техник редактор, гишүүдтэй байна. Техникийн редактораас бусад гишүүн тухайн шинжлэх ухааны салбарын тэргүүлэх зэргийн нэр хүнд бүхий гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид байна.
- 3.3 Сэтгүүлийн ерөнхий редактор олон улсын чансаа өндөртэй мэргэжлийн сэтгүүлд өгүүллээ хэвлүүлсэн эсвэл нэр хүндтэй сэтгүүлийн редакцад ажилладаг, шүүмж тогтмол хийдэг судлаач, дэд профессор түүнээс дээш цолтой байна.
- 3.4 Редакц нь сэтгүүлийг эрхлэн гаргаж буй нэгж дээр түшиглэн байгуулагдана.
- 3.5 Редакц нь сэтгүүлийн нийтлэлийн бодлогыг тодорхойлох, түүний хэрэгжилт, чанарыг үнэлэн дүгнэх, сэтгүүлийг хөгжүүлэх үйл ажиллагааг хариуцаж ажиллана.
- 3.6 Редакцын гишүүн нь салбарын тэргүүлэх зэргийн, олон улсын мэргэжлийн сэтгүүлд шинжээчээр ажиллаж байсан ба ажиллаж байгаа гадаад, дотоодын профессор, багш, судлаач байх эсвэл эрдэм шинжилгээний өгүүлэл, сэтгүүлд тавигдах бүтээлийг шинжлэх ухаан, онол, арга зүйн талаас нь хянан тохиолдуулна.
- 3.7 Редактор (ерөнхий болон туслах редактор) шаардлага хангаагүй өгүүллээс татгалзах ба сайжруулж засах, өгүүллийг буцаах эрхтэй.
- 3.8 Редактор нь өгүүллийн шинжлэх ухаанд шинэ мэдлэг бүтээсэн, салбарын тулгамдаж буй асуудлыг хөндсөн, шийдвэрлэсэн, арга замыг тодорхойлсон, судалгаанд суурилсан эсэх зэргийг эн тэргүүнд харгалзан үзнэ. Ерөнхий болон туслах редактор сэтгүүлд ирүүлж буй өгүүллийн Ouriginal, Plagscan программаар шалгах үүргийг хүлээнэ.
- 3.9 Редакцад МУБИС-ийн захирлын 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/313 тушаалаар баталсан журмын дагуу магистрант, докторантыг туслах ажилтан авч ажиллуулж болно.
- 3.10 Редакц нь сэтгүүлийг эрхлэн гаргах ажлыг хариуцаж, зохиогч болон шүүмжлэгчид зориулсан зөвлөмж гаргана. Редакц нь сэтгүүлийн дугаар бүрийн

- төсөлтэй танилцан, хэвлэлд шилжүүлэх, бүтээлийг хянан тохиолдуулагчийн ажлын хөлсийг тооцох үүрэгтэй.
- 3.11 Редакц нь сэтгүүлийн нэр хүндийг өсгөх талаар санал санаачилга гаргах, уулзалт зохион байгуулах, сэтгүүлийн талаар нийтэд сурталчлах, зохиогч, шүүмжлэгчид зориулсан хөтөч, гарын авлага, зөвлөмж зэргийг гаргах, бүтээлд "Эрдмийн ажлыг хэлбэржүүлэх нэгдсэн шаардлага"-ыг мөрдүүлэх эрхтэй.
- 3.12 "Лавай" болон бүрэлдэхүүний сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүлүүд "МУБИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл бичих шаардлага"-ийг мөрдөнө. (Хавсралт 2)
- 3.13 Лавай болон бүрэлдэхүүний сургуулийн сэтгүүлийн редакц нь ажлын товч тайлангаа жил бүрийн 6 дугаар сарын 15-нд ЭШИА-нд ирүүлнэ.
- 3.14 Лавай болон бүрэлдэхүүний сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийг JOL болгохтой холбоотой орон тооны, гэрээт, туслах ажилтан/ассистантшипээр ажиллуулж болно.

Дөрөв. Хянан тохиолдуулах үйл ажиллагаа

- 4.1 Эрдэм шинжилгээний сэтгүүл нь нийтлэлийн бодлого, эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлага хангасан бүтээлийг хүлээн авах ба сэтгүүлд нийтлүүлэх өгүүлэл тус бүрд мэргэжлийн хянан магадалгаа хийнэ.
- 4.2 Бүтээлийн шинэлэг тал, судалгааны арга зүй, ач холбогдол зэргийг бодитой үнэлэх, салбартаа идэвхтэй ажиллаж буй 2-3 эрдэмтэн судлаачаар бүтээлийг уншуулж хянан магадалгаа (шүүмж) хийлгэнэ.
- 4.3 Хянан тохиолдуулагч материалыг хүлээн авснаас хойш 2-4 долоо хоногийн дотор бүтээлийг уншиж, шүүмж өгнө.
- 4.4 Тухайн эрдэм шинжилгээний сэтгүүлийн шаардлага хангаагүй өгүүллийг хянан магадалгааны аль нэг шатанд зөвлөмж, тайлбарын хамт буцааж, сайжруулсан тохиолдолд сэтгүүлд дахин илгээж болно.
- 4.5 Хянан магадалгааг шинжлэх ухааны ач холбогдол, арга зүй талаас нь олон улсын стандартыг баримтлан хийнэ.
- 4.6 Бүтээлийг хэвлэх дүгнэлт гарсны дараа зохиогчийг солих зэргээр (өгүүлэлд) өөрчлөлт оруулахыг хориглоно. Дээрх нөхцөл үүсвэл сэтгүүлийн редакц зохиогчийн албан ёсны тайлбарыг авч асуудлыг шийдвэрлэнэ.

Тав. Урамшуулал

- 5.1 Сэтгүүлийн дугаар эрхэлсэн ерөнхий хянан тохиолдуулагч, редакцын гишүүдийн ажлын гүйцэтгэлийг "Багшийн ажиллах журам"-ын 3.7.17, 4.2.28-ыг үндэслэн тооцно.
- 5.2 Сэтгүүлийн редакцын гишүүдэд сэтгүүлээс нэг нэг хувийг олгож байна.
- 5.3 Гадаад болон бусад сургуулийн хянан тохиолдуулагчийн нэг өгүүлэлд хийх хянан магадалгааны хөлсийг 0.5 кредитээр тооцож олгоно.

Зургаа. Зохиогчийн эрх ба ёс зүй

- 6.1 "Лавай" болон бусад сэтгүүлд хэвлэгдсэн аливаа бүтээлийн зохиогчийн эрх нь зохиогч нарт байх ба сэтгүүл нь өгүүллийг Creative Commons Attribution 4.0 эрхийн хүрээнд олон нийтэд түгээх эрх эдэлнэ.
- 6.2 "Лавай" сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлүүд нь Creative Commons Attribution 4.0 олон улсын лиценз (CC BY)-ийн дагуу нийтлэгдсэн нээлттэй бүтээлүүд байна. Энэхүү CC BY лицензийн хүрээнд бүтээлийг эш татсан нөхцөлд түүнийг ашиглах, олшруулах, бусдад түгээж болох ба зохиогчдын нэрсийг заавал дурдсан байна.

- 6.3 Эрдэм шинжилгээний бүтээлийн хуулбарыг илрүүлэх лицензтэй программыг ашигладаг байна. Эх сурвалжийн давхцал /similarity/ нэг эх сурвалжаас 3 хувь, бүхэлдээ 25 хувиас хэтэрсэн бүтээлийг сэтгүүлд хүлээн авахыг хориглоно.
- 6.4 Урд өмнө хэвлэгдсэн хүснэгт, зургийг ашиглах бол тухайн бүтээлийн зохиогчийн эрх эзэмшигчээс зөвшөөрөл авч, түүнийгээ баримтаар нотолсон байна.
- 6.5 БСШУ-ны сайдын 454 дүгээр тушаалаар батлагдсан "Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн ерөнхий дүрэм"-ийн 4, 5 дугаар заалт болон ёс зүйн стандартыг (Compliance with Ethical Standards) мөрдөн ажиллана.
- 6.6 Бүтээл ашиг сонирхлын зөрчилгүй, шинжлэх ухааны өндөр түвшинд бичигдсэн байна.
- 6.7 Бусдын бүтээл, өгүүллийн хэсэг болон санаа хуулбарлаагүй байна.
- 6.8 Бүтээл нь анхдагч үр дүнтэй байна.
- 6.9 Хэвлэн нийтлүүлэх ёс зүйн асуудал гарсан тохиолдолд редакц нь хэвлэн нийтлэх ёс зүйн хороо (Committee on Publication Ethics, COPE)-ны удирдамжид тулгуурлан шийдвэрлэнэ <https://publicationethics.org>.
- 6.10 Бүтээл нь "Эрдмийн ажлыг хэлбэржүүлэх нэгдсэн шаардлага"-ыг хангасан байна.

Долоо. Сэтгүүл хэвлэлт

- 7.1 Сэтгүүлийн хавтасны эхний нүүр хэсэгт МУБИС-ийн лого, сэтгүүлийн нэр, дугаар, цахим болон хэвлэмэл олон улсын стандарт цуврал дугаар, featured article-ийг арын нүүрт хэвлэж болно.
- 7.2 "Лавай" сэтгүүл нь өгүүллийг DOI дугаартай цахим хэлбэрээр нийтийн хүртээл болгоно.
- 7.3 "Лавай" болон бүрэлдэхүүний сургуулийн сэтгүүлийг зөвхөн МУБИС-ийн хэвлэх цехээр хэвлэнэ.
- 7.4 Хэвлэх цаглавыг хичээлийн жилийн эхэнд редакцын хурлаар баталгаажуулна.

Найм. Санхүүжилт

- 8.1 "Лавай" сэтгүүлийг хэвлэн нийтлүүлэхтэй холбоотой зардлыг МУБИС-ийн эрдэм шинжилгээний төсөвт, бүрэлдэхүүн сургуулиудын хувьд өөрсдийн төсөвт тусгаж, сэтгүүл хэвлэх зардлаа санхүүжүүлнэ.
- 8.2 Сэтгүүл эрхлэн гаргах зардлыг гадаад, дотоодын байгууллагатай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд санхүүжүүлж болно.
- 8.3 Сэтгүүл эрхлэн гаргах нь ашгийн төлөө бус байна.
- 8.4 Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээр санхүүжиж болно.

Ес. Сэтгүүлийн үнэлгээ

- 9.2 "Лавай" болон бүрэлдэхүүний сургуулиас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлийг аргачлалаар үнэлнэ. (Хавсралт 1)
- 9.3 Эрдэм шинжилгээний сэтгүүлийг үнэлэх зөвлөлийг МУБИС-ийн захирлын тушаалаар хичээлийн жилийн эхэнд байгуулна.
- 9.4 Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, эрдэм шинжилгээ, инновацын албаны дарга, бүрэлдэхүүний сургууль бүрээс 1 профессорын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг үнэлгээг хийнэ.
- 9.5 Энэхүү үнэлгээг МУБИС-ийн багшийн ажиллах журмын 4.3.8-р заалтын дагуу кредит тооцох шалгуур болгоно.
- 9.6 Эрдэм шинжилгээний сэтгүүлийг үнэлэх ажлын хэсгээс "Хангалттай сайн", "Хангалттай" үнэлгээ авсан сэтгүүлийг МУБИС-ийн албан ёсны эрдэм

шинжилгээний сэтгүүлээр тооцож, жагсаалтад оруулж МУБИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

9.7 "Хангалтгүй" үнэлгээ авсан сэтгүүлийг МУБИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүлийн албан ёсны жагсаалтад оруулахгүй бөгөөд түүнд нийтлэгдсэн бүтээлд эрдэм шинжилгээний цаг тооцохгүй.

9.8 Эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийг хичээлийн жил бүрийн 5 сарын 25-ны дотор үнэлж, тайланг захиргааны зөвлөлийн хуралд эрдэм шинжилгээ, инновацын албаны дарга танилцуулна.

Арав. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

9.1 Сэтгүүлийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг эрхлэн гаргаж буй сэтгүүлийн редакц хариуцах ба нэмэлт, өөрчлөлтийг МУБИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

**МУБИС-ийн “Лавай” болон бүрэлдэхүүний сургуулийн эрдэм
шинжилгээний сэтгүүлийг үнэлэх аргачлал**

Зорилго. Лавай болон бүрэлдэхүүний сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүлийг үнэлэх, жагсаах, багш нарын эрдэм шинжилгээний цаг тооцоход энэхүү үнэлгээний аргачлалыг ашиглана.

1. Нэр томъёоны тодорхойлолт. Энэхүү аргачлалд хэрэглэсэн нэр томъёог дор дүрдсэн утгаар ойлгоно.
 - 1.1. p-ISSN – Олон улсын цуврал (тогтмол) хэвлэлийн стандарт дугаар – хэвлэмэл бүтээл
 - 1.2. e-ISSN - Олон улсын цуврал (тогтмол) хэвлэлийн стандарт дугаар – цахим бүтээл
 - 1.3. DOI - (DOI-Digital Object Identifier) - Дижитал объект дугаар
 - 1.4. ORCID - (Open Researcher and Contributor ID)-Судлаач, оролцогч нарын нээлттэй дугаар
 - 1.5. JPPS - (Journal Publishing Practices and Standards) framework-Сэтгүүл хэвлүүлэх практик ба стандартууд
 - 1.6. DOAJ – (Directory of Open Access Journals) – Эрдэм шинжилгээний нээлттэй сэтгүүлүүдийн лавлах
 - 1.7. Scopus – Elsevier компанийн олон улсын мэргэжлийн сэтгүүлийн үнэлгээ тооцдог мэдээллийн сан.
 - 1.8. Web of Science – Clarivate Analytics компанийн олон улсын мэргэжлийн сэтгүүлийн импакт фактор үнэлгээ тооцдог мэдээллийн сан.
2. Эрдэм шинжилгээний сэтгүүлийн чанарыг дараах шалгуур үзүүлэлт бүхий аргачлалын дагуу үнэлнэ.

Эрдэм шинжилгээний сэтгүүлийн чанарын үнэлгээний аргачлал

	Шалгуур, үзүүлэлт	Оноо (2,1,0)	Тайлбар
1. Нийтлэлийн бодлого			
1.1	МУБИС-ийн сэтгүүл эрхлэн гаргах журмыг баримталдаг эсэх		
1.2	Сэтгүүл нь нийтлэлийн бодлогоо томъёолсон эсэх		
1.3	Сэтгүүлийн зөвлөлийн гишүүд, зохиогч, шүүмжлэгч нарын хооронд ашиг сонирхлын зөрчил үүсэх асуудлыг шийдвэрлэх зохицуулалт туссан эсэх		
1.4	Сэтгүүл бүтээл хүлээн авахаас эхлэн хэвлэх хүртэлх үйл ажиллагааг бодлогодоо схемчилсэн эсэх		
1.5	Сэтгүүл нь шүүмжлэгчдийн нэрсийн жагсаалттай эсэх		
2. Сэтгүүлийн Зөвлөл			
2.1	Зөвлөлийн гишүүдийг салбарын гадаад, дотоодын тэргүүлэх зэргийн профессор, судлаачдаар бүрдүүлсэн эсэх		

2.2	Зөвлөлийн гишүүдийг сонгохдоо улс орон, газар нутгийн тархалт, хүйсийн тэгш эрхийг тооцсон эсэх		
2.3	Зөвлөлийн гишүүдийн талаарх мэдээллийг сэтгүүлийн цахим хуудсанд байршуулсан эсэх		
2.4	Зөвлөлийн гишүүд нь бүтээлийг хэвлэх шийдвэрийг гаргадаг эсэх		
2.5	Зөвлөлийн гишүүдийн эрх, үүргийн тодорхойлсон эсэх		
3. Бүтээлийн агуулга			
3.1	Хураангуй: сэдвийн судлагдсан байдал, үндэслэл, судалгааны арга, үр дүн, дүгнэлт туссан эсэх		
3.2	Удиртгал: судалгааны асуудал, зорилго, таамаглал, судалгааны ач холбогдлыг тодорхойлсон эсэх		
3.3	Арга: судалгааны дизайн, хамрах хүрээ, арга, өгөгдөл цуглуулах техник, өгөгдлийн анализ, лицензтэй программ ашигласан эсэх		
3.4	Үр дүн: судалгааны асуудлыг баталсан эсэх		
3.5	Дүгнэлт: судалгааны үр дүнг оновчтой томъёолсон эсэх		
4. Бүтээлийн бичвэр, формат			
4.1	Бүтээлийн нүүр хэсэг стандарт хангасан эсэх		
4.2	Бүтээлийн гарчиг хураангуй, байгууллагын хаяг англи хэл дээр бичигдсэн эсэх		
4.3	Эшлэл, график, хүснэгт, ном зүйг APA стандартын дагуу бичсэн эсэх		
4.4	Өгүүлэлд ашигласан ном зүйгээс эш татсан эсэх		
4.5	Зургийн чанар олон улсын стандартыг хангасан эсэх		
5. Хянан магадалгаа			
5.1	Хянан магадалгаа хийх тогтолцоотой эсэх		
5.2	Шүүмжлэгч нарт зориулсан зөвлөмжтэй эсэх		
5.3	Бүтээлийн хуулбарлалтыг илрүүлдэг программ ашигладаг эсэх		
5.4	Бүтээлийн хянан магадалгааг 2-оос дээш шүүмжлэгч хийдэг эсэх		
5.5	Шүүмжлэгч нарын урамшууллын хэлбэрийг тодорхойлсон эсэх		
6. Сэтгүүл хэвлэлт			
6.1	Сэтгүүл цахим хуудастай эсэх		
6.2	Сэтгүүл төлбөртэй эсэх		

6.3	Цаглаврын дагуу хугацаандаа тогтмол хэвлэгддэг эсэх (2-4 удаа)		
6.4	Сэтгүүлд доод тал нь 10 өгүүлэл хэвлэгддэг эсэх		
6.5	Бүтээл хүлээн авах арга замыг тайлбарласан эсэх		
7. Сэтгүүлийн индексжүүлэлт			
7.1	p-ISSN-тэй		
7.2	e-ISSN-тай эсэх		
7.3	DOI дугаартай эсэх		
7.4	ORCID дугаартай эсэх		
7.5	Олон улсын салбарын хүлээн зөвшөөрөгдсөн систем, сэтгүүлийн үнэлгээний платформуудад бүртгэгдсэн эсэх - JPPS - DOAJ - Scopus - Web of Science (SCIE, SSCI, AHCI, ESCI)		
8. Зохиогчийн эрх ба ёс зүй			
8.1	Зохиогч холбогдолтой мэдээллээ илгээдэг эсэх /цахим хаяг, албан хаяг, холбоо барих утас/		
8.2	Зохиогчийн бүтээлийг эзэмших эрхийн гэрээг хийдэг эсэх		
8.3	Зохиогчийн эрхийн зөрчлийг олон улсын хэм, хэмжээг мөрдөж шийдвэрлэдэг эсэх		
8.4	Судалгаанд ургамал, амьтан, хүний мэдээллийг ашиглахдаа ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдсөн эсэх		
8.5	Зохиогчийн эрх, үүргийг тодорхойлсон эсэх		
	Нийт оноо		

3. Эрдэм шинжилгээний сэтгүүлийн чанарыг үнэлэх шалгуурыг 2, 1, 0 гэсэн оноогоор үнэлэх ба нийт 80 оноо авах ба үсгэн үнэлгээгээр илэрхийлбэл:

Хангалттай сайн	80-70
Хангалттай	70-60
Хангалтгүй	59-1



МУБИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл бичих шаардлага

МУБИС-ийн "Лавай" болон бүрэлдэхүүний сургуулийн сэтгүүлд өгүүлэл бичиж буй зохиогчид энэхүү зөвлөмжийг баримтална.

Нэг. Судалгааны өгүүллийн бүтэц

Сэдэв буюу гарчиг

Өгүүллийн гарчиг нь өгүүллийн гол санааг агуулсан товч, тодорхой, оновчтой томъёологдсон 11-оос дээшгүй үгэнд багтсан, Times New Roman, 11 pt, **Bold**, мөр голлон бичигдсэн байна. **Бүлгийн гарчиг** Times New Roman, 11 pt, эхний үсэг томоор, **Bold**, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.

Зохиогчийн хаяг

Байгууллагын нэр, нэгжийн нэр, зохиогчийн овог, нэрийг товчлохгүй Times New Roman, 11 pt, баруун талд зэрэгцүүлэн бичнэ.

Хураангуй

Хураангуй нь судалгааны ажлын агуулгын гол утга санааг товч тодорхой, ойлгомжтой байдлаар илэрхийлсэн монгол хэл дээр 150-250 орчим үгээс бүрдэнэ. *Хураангуйг Times New Roman дээр 11 pt үсгийн өндөртэйгөөр бичнэ.*

Түлхүүр үг

Өгүүллийн утгыг илэрхийлж чадахуйц 8 хүртэлх нэр үг ба холбоо үгийг, зүүн талд зэрэгцүүлэн бичнэ. Өгүүллийн нэр орсон үг түлхүүр үгэнд орохгүй.

Удиртгал

Судалгааны арга, зорилго, зорилт, хэрэгцээ шаардлага, дэвшүүлж буй асуудал, таамаглал дэвшүүлсэн зэргийг дурдана.

Судалгааны арга зүй

Судалгааны хамрах хүрээ болон судалгааг ямар арга, аргачлалаар боловсруулсан, чанар, тоон үзүүлэлт бүхий статистик боловсруулалтын аргачлалыг бичнэ.

Судалгааны үр дүн

Энэхүү хэсэгт судлаач гаргасан үр дүнгээ баталгаатай логик, дэс дараалал сайтай, эмх цэгцтэй, ойлгомжтой бичнэ.

Дүгнэлт

Судалгааны ажлын үр дүнгээс ямар дүгнэлтэд хүрч байгааг шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэж бичнэ.

Ном зүй

Ном зүйг APA форматын дагуу бичнэ.

Сэдэв буюу гарчиг

Өгүүллийн гарчиг нь өгүүллийн гол санааг агуулсан товч, тодорхой, оновчтой томъёолон **англи хэл** дээр 11-оос дээшгүй үгэнд багтсан, Times New Roman, 11 pt, **Bold**, мөр голлон бичигдсэн байна.

Зохиогчийн хаяг

Албан байгууллагын хаягийг товчлолгүй үгчлэн бичих, зохиогчийн овог, нэрийг Times New Roman, 11 pt, баруун талд зэрэгцүүлэн англиар бичнэ.

Хураангуй

Хураангуй нь судалгааны ажлыг бүтцийг хураангуйлж, ойлгомжтой байдлаар илэрхийлсэн орос эсхүл англи хэл дээр 150-250 орчим үгээс бүрдэнэ. Хураангуйг Times New Roman дээр 11 pt үсгийн өндөртэйгөөр бичнэ.

Түлхүүр үг

Өгүүллийн утгыг илэрхийлж чадахуйц 6-8 нэр үг ба холбоо үгийг Times New Roman, 10 pt, зүүн талд зэрэгцүүлэн англиар бичнэ. Өгүүллийн сэдэвт орсон үг түлхүүр үгэнд орохгүй.

Хоёр.Бүтээлд тавих шаардлага

А. Техник шаардлага

- ЭШӨ нь 297x210мм (A4) хэмжээтэй 10-15 хуудсанд багтсан байна.
- Өгүүллийг Microsoft Office Word программыг ашиглан Times New Roman фонт, 11 pt үсгийн өндрийг сонгон бичнэ.
- Өгүүллийг A4 хэмжээний цаасан дээр хуудасны дээд, доод талаас 3 см, баруун, зүүн талаас 2,5 см зайг үлдээж бичнэ. Өгүүллийг бичихдээ header, footer, командыг ашиглахгүй.
- Хүснэгт, зураг, график нь өгүүлэлд орсон дарааллаараа дугаарлагдана. Хүснэгт, зураг, графикийн гарчиг нь Times New Roman фонд дээр 11 pt үсгийн өндөртэйгөөр баруун талдаа зэрэгцэнэ. Хүснэгт болон график доторх текстийн үсгийн өндөр Times New Roman фонд дээр 10 pt байна. Жишээ:

Хүснэгт 2

Бага боловсролын математикийн дидактик хичээлээр хасагдсан агуулга

№	Судлагдахуун	ББМД ⁴ хичээлээр хасагдсан агуулга /1951-2016/
1	Ерөнхий заах арга	2 ангитай зэрэг ажиллах хичээлийн төлөвлөгөө Сурагчдын дэвтрийн ажиллагаа бичгийн ажлыг явуулах ба шалгах
2	Тоо тоолол заах арга	Сампин дээр нэмэх, хасах
3	Алгебрын материал заах арга	Хийсвэр тооны томьёо зохиож бодлого бодох
4	Геометр заах арга	Газар дээр шулуун байгуулах ба түүнийг хэмжих

⁴ Бага боловсролын математикийн дидактик

Зураг 1
Буган хөшөөн дээрх бүсний хэлбэрүүд





График 1
Туршилтын

бүлгийн үр дүн



Б. Агуулгад тавигдах шаардлага

- Эрдэм шинжилгээний өгүүлэл нь сэдвийн хүрээнд шинэлэг, импакт факторын үзүүлэлт бүхий сэтгүүлийн эрдэмтэн, судлаачдын бүтээлээс иш татаж, шинжилгээний тодорхой аргачлалыг хэрэглэсэн, судалгаа нь туршилт судалгаанд суурилсан, сэдвийн хүрээнд шинэлэг санааг дэвшүүлсэн, түүнийг судалгааны ажлын үр дүнгээр баталсан, ач холбогдол бүхий судалгаа байна.
- МУБИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдэх материал нь бусад эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдээгүй байх.
- Эшлэл, ном зүйг АРА загвараар бичиж гүйцэтгэсэн байна.

Эшлэл бичих шаардлага

Шууд эшлэл / Зохиогчийн бичсэн агуулгыг өөрчлөлгүйгээр шууд эшлэх/

1. Нэг зохиогчтой бүтээлээс эшлэл авах

"Эшлэл" (зохиогчийн нэр, он, хуудасны дугаар).

"Багш өөрийн үйл ажиллагааны хамгийн бэрхшээлтэй багш, сурагч, хичээлтэй уялдаатай тодорхой асуудлыг сонгох хэрэгтэй" (Батхуяг, 2018, х.5).

"Citation" (Author & Author, year, p).

"A new genre of writing and mode of research has arrived on the anthropological stage: multispecies ethnography" (Kirksey & Helmreich, 2010, p.3).

2. Зохиогч нь тодорхойгүй тохиолдолд эрхлэн гаргасан байгууллагын нэрийг бичнэ

"Эшлэл" (Байгууллагын нэр, он, хуудасны дугаар).

"Хоол тэжээлийн талаарх хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангаж, хоол тэжээлээс хамааралтай өвчин, эмгэгийг бууруулахад оршино" (Монгол улсын засгийн газар, 2015, х.2).

"Citation" (Institution , year, p)

"Use secondary sources sparingly, for instance, when the original work is out of print, unavailable through usual sources, or not available in English" (American Psychological Association, 2012, p.178).

3. *Хоёр зохиогчтой бүтээлээс эшлэл авах*

"Эшлэл" (зохиогчийн нэр & зохиогчийн нэр, он, хуудасны дугаар).

"Багш өөрийн үйл ажиллагааны хамгийн бэрхшээлтэй багш, сурагч, хичээлтэй уялдаатай тодорхой асуудлыг сонгох хэрэгтэй" (Батхуяг & Бурмаа, 2018, х.5).

"Citation" (Author & Author, year, p).

"A new genre of writing and mode of research has arrived on the anthropological stage: multispecies ethnography" (Kirksey & Helmreich, 2010, p.3).

Зохиогчийн нэр & зохиогчийн нэр (он), "Эшлэл".

Батхуяг & Бурмаа (2010), Багш өөрийн үйл ажиллагааны хамгийн бэрхшээлтэй багш, сурагч, хичээлтэй уялдаатай тодорхой асуудлыг сонгох хэрэгтэй".

Author & Author (year), "Citation".

As Kirksey and Helmreich (2010) argue, "[a] new genre of writing and mode of research has arrived on the anthropological stage: multispecies ethnography".

4. *Гурав ба түүнээс дээш зохиогчтой бүтээлээс эшлэл авах*

"Эшлэл" (зохиогчийн нэр, зохиогчийн нэр, зохиогчийн нэр, он, хуудасны дугаар).

- "Тогтворшилтой хөгжлийн төлөөх боловсролын хамгийн гол шинж нь амьдралын туршдаа суралцах чадвар, бүхэллэг байдал ба хичээл хоорондын харилцан хамаарал зэргийг болон бүтээлч эрэл хайгуул, эргэцүүлэх сэтгэлгээ, тогтолцооны сэтгэлгээ, асуудал шийдвэрлэхүйд түшиглэх зэргийг онцгойлон дэмждэг явдал" (Жадамбаа, Сандагдорж, Тунгалаг, Эрдэнэчимэг, 2015, х.5).

"Citation" (Author, Author, Author, year, p).

"This multi-sensory experience is closed by reviewing actions students can take, including individual conservation behaviors, talking to friends and family about climate change, and joining an ACE climate club to undertake a conservation project in the school community" (Flora, Melissa, Matt, 2014, p. 423).

Бүтээлийн дунд эшлэл

- "Тогтворшилтой хөгжлийн төлөөх боловсролын хамгийн гол шинж нь амьдралын туршдаа суралцах чадвар (Жадамбаа 2015a), бүхэллэг байдал ба хичээл хоорондын харилцан хамаарал зэргийг болон бүтээлч эрэл хайгуул, эргэцүүлэх сэтгэлгээ (Жадамбаа 2015c), тогтолцооны сэтгэлгээ, асуудал шийдвэрлэхүйд түшиглэх зэргийг онцгойлон дэмждэг явдал" (Жадамбаа 2015b, х.5).

In-text citation

In his work on rock art (Bednarik, 2001, 2003a). He also has interest in the watercraft during the Pleistocene (Bednarik, 2003c) and the figurines of Africa (Bednarik, 2003b)

Шууд бус эшлэл /Зохиогчийн санааг утгыг нь алдагдуулахгүйгээр өөрийн үгээр тайлбарлан утгачилж эшлэх/

Боловсролын төсөв нь боловсролын үйлчилгээг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл бөгөөд боловсролын чанарт нөлөөлдөг чухал хүчин зүйлүүдийн нэг юм. Боловсролын үйлчилгээг нийтэд хүргэхийн тулд төсвийн бүрдүүлэлтийн баталгаатай байдлаас гадна бас төсвийн хуваарилалт чухал байдаг (Kong Chun, 1989, х.33).

Recent extreme weather events serve as reminders of just one way that climate change could upend youths' communities, lifestyles, and economic prospects overnight. If youth are to protect their future prospects from climate change, they must be empowered with knowledge of climate science, motivation to mitigate climate

change, and confidence to take climate-friendly action at the individual and community levels (Flora, Melissa, Matt, 2014, p. 420).

Дам эшлэл /Зохиогчийн санааг бусдын эшилснээс авч эшлэх/

Равжаагийн цаасан шувуу сургаалд, багшийн эрдэм мэдлэг хэдий их биш ч уян зөөлөн, сэтгэл гаргагч бол шавьд эрдмийг харамгүй заахыг сургасан нь эрдэм заагч багшид сэтгэл байхад эрдмийг зааж болно хэмээжээ (Ганхуягийн эшилснээс, 2011, х.6).

Another nationally representative survey reported that youth hold weaker intentions to perform climate-friendly behaviors and take fewer climate-friendly actions than their parents (as cited in Mead et al, 2012, х.420).

Ном зүй бичих шаардлага

Ном зүйн жагсаалтыг эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудын хавсралтын өмнө оруулна. Ном зүй нь тухайн судалгаа, боловсруулалтын ажил ямар чиглэл хүрээний, хэдий хэмжээний эх сурвалж, баримт хэрэглэснийг илэрхийлэн харуулдаг төдийгүй тухайн бүтээлийг уншиж танилцаж байгаа хүнд эх сурвалжийг магадлах эсвэл цааш сонирхон судлах замыг нээж өгдөг мэдээллийн чухал хэрэгсэл юм.

Ном зүйн формат

2.1 Судалгааны ажлын ном зүйн нэршлийг Times New Roman, 11pt, тод (Bold)-оор, хуудасны зүүн гар талд "Ном зүй" гэсэн үгийг догол мөргүй, эрдэм шинжилгээний өгүүллийн ном зүйн нэршлийг Times New Roman, 11pt, эхний үсгийг томоор, тод (Bold)-оор зүүн гар талд "Ном зүй" гэсэн үгийг догол мөргүй тус тус бичнэ. Үүний араас ном зүйн жагсаалтыг нэг мөр алгасаж, эх сурвалжуудыг дугаарлахгүй, зохиогчийн нэрийг мөрийн эхнээс бичиж, дараагийн мөрүүдийг догол мөрнөөс, зохиогчийн нэрийг харахад хялбар байдлаар бичнэ. Мөн мөр хоорондын зай (Spacing: After 0pt, Before 0pt) байна.

1. Ном зүйн бичилтийн загвар

Нэг зохиогчтой ном/ book

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар.

Lastname, F. M. (Published year). *Book title*. City, State: Publisher.

Хоёр зохиогчтой ном/book

Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар.

Lastname, F. M., Lastname, F. M. (Published year). *Book title*. City, State: Publisher.

Гурваас таван зохиогчтой ном/book

Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар.

Lastname, F. M., Lastname, F. M., Lastname, F. M. (Published year). *Book title*. City, State: Publisher.

Зохиогч нь 6 ба түүнээс дээш тохиолдолд эхний зургаан зохиогчийн нэрийг бичиж, бусад зохиогчдын нэрсийг "бусад" гэсэн товчлолоор тэмдэглэнэ.

Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., бусад. (хэвлэсэн он). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар.

Lastname, F. M., Lastname, F. M., Lastname, F. M., Lastname, F. M., Lastname, F. M., Lastname, F. M. et al. (Published year). *Book title*. City, State: Publisher.

Нэг зохиогчтой хэд хэдэн ном/book

Нэг зохиогчтой хэд хэдэн эх сурвалжийг ном зүйд бичилт хийхдээ хэвлэсэн он дарааллаар байршуулна.

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он /2000). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он /2005). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар

Lastname, F. M. (year/2000). *Book title*. City, State: Publisher.

Lastname, F. M. (year/2005). *Book title*. City, State: Publisher.

Нэг зохиогчтой нэг онд хэвлэгдсэн хэд хэдэн бүтээл/book

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он /2000). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он /2000 а). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он 2000 b). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар

Lastname, F. M. (year/2000). *Book title*. City, State: Publisher.

Lastname, F. M. (year/2000a). *Book title*. City, State: Publisher.

Lastname, F. M. (year/2000b). *Book title*. City, State: Publisher.

Байгууллагаас эрхлэн гаргасан бүтээл/book

Байгууллагын бүтэн нэр. (хэвлэсэн он). *Бүтээлийн нэр*. (дугаар). Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар.

Organization name(s). (Published year). *Book title*. Location: Publisher.

Нэг зохиогчтой ном/ book-DOI

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар. doi:xx.xxxxxxxx

Lastname, F. M. (Published year). *Book title*. City, State: Publisher. doi:xx.xxxxxxxx

Тайлбар толь, номын бүлэг/ reference book, book chapter-DOI

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). Номын бүлгийн нэр. Редакторын нэр. Овгийн эхний үсэг. (ред). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар. doi:xx.xxxxxxxx

Lastname, F. M. (Published year). Title of chapter or entry. A.Editor (ed), *Book title*. City, State: Publisher. doi:xx.xxxxxxxx

2. Сэтгүүл /Journal

Хэвлэмэл сэтгүүл

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он /2000/). Өгүүллийн нэр. *Сэтгүүлийн нэр, дугаар, хуудасны дугаарууд.*

Lastname, F. M. (Published year). Article title. *Journal Title, Volume(Issue), Page(s).*

Хэвлэмэл сэтгүүл /DOI-7 болон түүнээс дээш

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он /2000/). Өгүүллийн нэр. *Сэтгүүлийн нэр, дугаар, хуудасны дугаарууд.* doi:xx.xxxxxxxx

Lastname, F. M. (Published year). Article title. *Journal Title, Volume(Issue), Page(s).*
doi:xx.xxxxxxxx

Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., ... Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). Бүтээлийн нэр. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар.

Lastname, F. M., Lastname, F. M., Lastname, F. M., Lastname, F. M., Lastname, F. M., ... Lastname, F. M. (Published year). Book title. City, State: Publisher.

Сонин/Newspaper

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он, сар, өдөр). Өгүүллийн нэр. *Сонины нэр, дугаар, хуудасны дугаарууд.*

Lastname, F. M. (Year, Month Day published). Article title. *Newspaper Title, Page(s).*

Патент/Patent

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). *Патент олгосон улсын нэр дугаар.* Retrieved from <https://www.someaddress.com/full/url/>

Lastname, F. M. (Published year). Patent number. Retrieved from <https://www.someaddress.com/full/url/>

Хууль эрх зүйн баримт/Legislative materials

Эрх зүйн баримтын нэр батлагдсан он (Баталсан байгууллагын нэрийн товчлол/УИХ) (Байршил).

Short name act year. (Jurisdiction abbreviation). (Country abbreviation)

Тушаал

Тушаалын нэр/ дугаар, байгууллагын нэр (он)

Title/ number, volume source xxx (year)

Тогтоол

Тогтоолын нэр. No. хуудсын дугаар (он)

Ехес. Order No. xxxxx page (year)

Жич: Цахим хуудас, сурах бичгээс эшлэл авахыг хориглоно.